

ХК өөрийн цахим хуудсанд Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд зориулсан цэстэй байх тухай зөвлөмж

Аливаа компанийн мэдээллийн гол эх сурвалжийн нэг нь түүний цахим хуудас бөгөөд нээлттэй ХК-ийн хувьд өөрийн цахим хуудсаараа дамжуулан одоогийн хувьцаа эзэмшигчид болон ирээдүйн хөрөнгө оруулагч нартаа зориулсан мэдээллийг хүргэх нь хувьцаа эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлэх, улмаар хөрөнгө оруулагчдыг татах өргөн боломжийг нээдэг. Энэ нь олон улсын сайн туршлагын нэг бөгөөд энэ талаар хууль журамд ч тодорхой заасан байдаг. Иймд бид Та бүхнийг өөрийн цахим хуудсандаа хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нартаа зориулсан тусгай цэсийг бий болгож, цаашид хөгжүүлэн ажиллахыг зөвлөж байгаа бөгөөд үүнд дараах мэдээллийг оруулахыг санал болгож байна.

ХК-ийн цахим хуудасны Хувьцаа эзэмшигч/Хөрөнгө оруулагчдад зориулсан цэсийн товч Агуулга:

- **САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛҮҮД**
 - Хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан
 - Хөндлөнгийн аудитын дүгнэлт

- **САНХҮҮГИЙН БУС МЭДЭЭЛЛҮҮД**
 - **Компани:** танилцуулга, бүтэц зохион байгуулалт, стратеги, зорилго зорилт
 - **Тайлан:** Үйл ажиллагааны жилийн тайлан /он бүрээр/
 - **Засаглал:** ТУЗ, түүний хороод, гүйцэтгэх удирдлагын багийн мэдээлэл...
 - **Үнэт цаас:** ХЭ-гчдийн бүтэц, мэдээллээр хангах этгээдийн холбоо барих ...
 - **Шуурхай мэдээлэл:** ХЭХ-ийн зар, үнэ ханшид нөлөөлөх цаг үеийн мэдээллүүд...

Хөрөнгө оруулагч/Хувьцаа эзэмшигчдэд зориулсан цэсийн дэлгэрэнгүй:

- Санхүүгийн мэдээллүүд буюу улирал, хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлтийн хамт
- Санхүүгийн бус мэдээллүүд буюу үйл ажиллагааны тайлан мэдээллүүд:
 - Компанийн үйл ажиллагааны танилцуулга, бүтэц зохион байгуулалт, стратеги, зорилго зорилт, үйл ажиллагааны жилийн тайлан /он бүрээр/
 - ТУЗ, түүний хороод болон гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүд, тэдгээрийн боловсрол, ажлын туршлага, ур чадвар, эзэмшиж буй хувьцааны тоо хэмжээ, зардал, шагнал урамшууллын мэдээлэл, ТУЗ-ийн болон компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм журмууд
 - Үнэт цаасны мэдээлэл, ногдол ашиг, ханшийн мэдээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, томоохон хөрөнгө оруулагчид болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл, хувьцаа эзэмшигчидтэй харилцах, тэдгээрийг мэдээллээр хангах нэгж, холбогдох этгээдийн мэдээлэл г.м.

- Шуурхай мэдээ: Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээлэл, хувьцаа эзэмшигчдэд зориулсан үйл явдлын календарь, цаг үеийн мэдээллүүд...

Эдгээр нь заавал байвал зохих наад захын мэдээллүүд ба олон улсын сайн туршлага дээр үндэслэн өөр бусад мэдээллүүдийг нэмж оруулах нь Та бүхний өмнө нээлттэй. Мэдээллийг **тогтмол** /тодорхой хугацаанд/ хүргэх мэдээлэл болон **шуурхай** /тухай бүр/ хүргэх чухал үйл явдлын мэдээлэл гэсэн байдлаар ангилж, түүнийг мэдээлэх ажлыг хариуцан хийх этгээдийг томилсон байх хэрэгтэй.

Түүнчлэн Компанийн засаглалтай холбоотой нэмэлт мэдээллүүд болох ТУЗ болон ТУЗ-ийн хороодын тухай мэдээлэл, тэдгээрийн үүрэг хариуцлага, үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагаанд учирч болох эрсдлүүд, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл, тэдгээрийг батлах, мэдээлэх бодлого журам, Монголын компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж байгаа байдал, үгүй бол түүний шалтгаан зэргийг тусгасан мэдээллийг оруулах нь зүйтэй.

Дээрх зөвлөмжийг тусгасан хууль журмын заалтууд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56, 79 дугаар зүйл
- Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйл, 88.4 дахь заалт
- Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам” <http://frc.mn/>
- Монголын Хөрөнгийн биржийн Бүртгэлийн журмын 18 дугаар зүйл <http://mse.mn/>
- “Монголын компанийн засаглалын кодекс”-ийн 7.1, 7.2, 7.3 дахь заалтууд

Түүнчлэн компанийн засаглалыг хөгжүүлэхэд тус нэмэр болох дараах үлгэрчилсэн журмууд гарсныг Та бүхэнд сонордуулж байна. [http://frc.mn/Компанийн засаглал/Хууль тогтоомж/Дүрэм, журам/](http://frc.mn/Компанийн_засаглал/Хууль_тогтоомж/Дүрэм,_журам/)

- ТУЗ-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам
- Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үлгэрчилсэн журам
- ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны үлгэрчилсэн журам
- ТУЗ-ийн аудитын хорооны үлгэрчилсэн журам
- ТУЗ-ийн цалин урамшууллын хорооны үлгэрчилсэн журам
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын үлгэрчилсэн журам
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ерөнхий заавар

Та бүхэн мэдээ мэдээллээ зөвхөн монгол хэл дээр гаргахаас гадна өөр бусад хэл дээр гаргаж хэвшвэл гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх болно гэдгийг мөн санах нь зүйтэй гэж зөвлөж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ НЭГЖ
cgovernance@mse.mn